



**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоол, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2018 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Цэрэнлхам/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.АРИУНБАЯР

315060000147



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
НЭГ. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
1	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох	Тухай бүр	ЗХ ЭБАТ	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байна.
2	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Тухай бүр	ЗХ	Хүний нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байна.

3	4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	Албан тушаалтанд тавигдах ёс зүйн, мэдлэг, боловсрол, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Тухай бүр	Удирдлага ЗХ	Албан тушаалтны мэдлэг боловсрол, ур чадвар, ажлын үр дүнгийн үзүүлэлтийг харгалзан албан тушаалд томилно.
4	4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Албан тушаалтанд холбогдох авлига ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Тухай бүр	ЗХ ХДХА	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байна.
5	4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	Жилдээ	ЗХ ХДХА	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдыг сургалтад хамруулна.
ХОЁР. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
1	4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	Тухай бүр	Удирдлага ЗХ	Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн гаргана.

ГУРАВ. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

1	4.1.3.1. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх	Сар бүр	СААХ	Цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах мэдээллийг хүргэж хэвшсэн байна.
2	4.1.3.4. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх	Улирал бүр	СААХ ЗХ	Дүн шинжилгээ хийсэн байна.